



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 07/32-01

Сүхбаатар сум

Зөрчил арилгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн ДА-2025/01/ҮА-ОНА дугаартай удирдамжийн дагуу Сэлэнгэ Цэнгэг ус ААТҮГ-ын 2023-2024 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний албан томилолтын зардлыг 2023 онд 8,476,000.0 (Найман сая дөрвөн зуун далан зургаа мянган төгрөг)-өөр, 2024 онд 12,659,662.0 (Арван хоёр сая зургаан зуун тавин есөн мянга зургаан зуун жаран хоёр төгрөг)-өөр, нийт 21,135,662.0 (Хорин нэгэн сая нэг зуун гучин таван мянга зургаан зуун жаран хоёр төгрөг)-өөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.Захирал дараах эрх, үүрэгтэй: 20.1.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулсан биелэлтийг хангах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ." гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аймгийн Засаг даргаар батлуулсан санхүүгийн төлөвлөгөөний дагуу зардлын ангиллыг хэтрүүлэхгүй байх.
2. Цаашид дээрх зөрчлийг дахин давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ Цэнгэг Ус

4325005019

ААТҮГ-ын дарга А.Алтансүх, Ерөнхий нягтлан бодогч Г.Сувд нарт даалгав.

3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН

ЗӨВШӨӨРСӨН:

СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС ААТҮГ-ЫН
ДАРГА
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

А.АЛТАНСҮХ
Г.СУВД